

**ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН
ХАРИЛЦАА**



**БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААН ДАХЬ
ХУДАЛДААНЫ АСУУДЛУУД
(Монгол Улсын жишээн дээр)**

Т.Мөнхбаяр*

***Abstract:** During the transition to market system, it has implemented consistently activities for the liberalization of foreign trade, including the accession for multilateral trade agreements and reduction of our own barriers to trade. Although Mongolia has organized some agreements on bilateral trade and economic cooperation with much more 30 countries, it has never joined any commitment of trade and economy. Today, it is considered as expression of adhering free and open trade policy regardless of that Mongolia is only one country within member countries of WTO, not joined any particular economic commitment. In recent years, the significance of joining the particular trade-economic commitment and organizing FTA is growing more and more. For instance, we have overcome successfully the crisis in the beginning of economic transition, then tended to increase constantly the economy and increased much more amount of foreign trades than previous years. Especially, FTA is so crucial to organize the market for exporting. Countries joined any FTA are mutually committed to significantly reduce the customs tariffs on trade within each other, completely 'zero-rate' if possible and reduce the amount of non-tariff barriers to the lowest level possible. It should be noted that the necessity to explore the possibility of conclude free trade agreement with the main partner countries of regional trade including Japan, Korea, China and Russia, is not just related to the close geographical location with these countries, but also to the high proportion of these countries taking in the foreign trade of Mongolia and growing reciprocity in trade.*

Key words: WTO, FTA, Mongolia, Japan, China, Russia

* * *

Ийнхүү улс орнуудаас бодлогоор бий болгож буй бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцийн бүлэглэлүүд нь оролцогч талуудын хувьд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн таатай нөхцөлийг бүрдүүлж байгаа тул энэ асуудал улам бүр судлаачдын анхаарлыг татаж, илүү судлагдах болжээ. Монголын өнөөгийн эдийн засгийн хямралаас гарах арга замыг хайж байгаа нөхцөлд олон улсын худалдаа, бүс нутгийн интеграцийн чиглэлээр судалгаа хийж, олон улсын эрх зүйн орчин, бусад орны туршлагад тулгуурлан, бүс нутгийн интеграцид нэгдэх өөрийн гэсэн санал, зөвлөмжийг боловсруулах нь эл судалгааны ажлын зорилго болж байна.

Сүүлийн жилүүдэд бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграци эрчимжиж, эл үйл явцад үндсэндээ дэлхийн бүх улс орнууд оролцох болсноос гадна энэ асуудал ДХБ-ын хүрээнд явагдаж байгаа худалдааны олон талт хэлэлцээн дээр байнга яригдаж байгаа тул энэ чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгаа,

* МУИС, ОУХНУС-ийн магистрант

бүтээл олон хэвлэгдэн гарсан байна. Харин Монголын хувьд энэ асуудлыг өөрийн орны эдийн засгийн эрх ашиг, сонирхолтой холбон цогцоор нь судалсан, тодорхой орон, бүлэглэлтэй нэгдэхэд үүсэх нөхцөл, эерэг ба сөрөг талуудын тооцож гаргасан, тэдгээр судалгааны талаар үндэсний хэмжээнд нэгдсэн ойлголттой болсон зүйл одоогоор байхгүй байна. Уг асуудлыг олон талаас нь, харилцан уялдаанд нь судалж дүгнэсэн, бүс нутгийн худалдааны харилцааг боловсронгуй болгох, эрчимжүүлэх, тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр авах арга хэмжээний талаар хийсэн эрдэм шинжилгээний цогц судалгаа, бүтээл хомс байна.

Энэхүү судалгааг хийхдээ сэдвийнхээ хүрээнд үндсэн эх булаг, материалуудыг түлхүү ашиглах, тэдгээрийг хооронд нь харьцуулах, жиших, анализ хийж дүгнэлт гаргах, зарим тоо баримтыг хялбаршуулан зураг, хүснэгтээр харуулах, эцэст нь шинжлэх ухааны үндэслэлтэй санал, зөвлөмж боловсруулах зэрэг аргуудыг өргөн хэрэглэсэн болно.

Судалгааг үр дүнтэй байлгах зорилгоор үндсэн нөхцөл болох чанарын болон чанарын бүс аргуудыг хослуулан хэрэглэх юм. Чанарын аргаар судалсан судалгааны дүнг боловсруулахаас гадна эдийн засаг, статистикийн мэдээллийг боловсруулахад тоон судалгааны аргуудыг үндсэн хэрэгсэл болгоно. Хувьсагчдын хоорондын харилцан хамаарлын шинжилгээ, статистикийн ач холбогдол, стандарт алдааны шинжилгээ зэрэг судалгааны чанарын олон арга, судлах хувьсагчийг сонгоход зам заагчийн үүргийг гүйцэтгэх болно. Мөн тусгай программ хангамжийн тусламжтайгаар санхүүгийн шинжилгээ, үнэлгээ хийх, орон зай мэдээллийн зураглал боловсруулах ажлыг гүйцэтгэх, шугаман бүс системийн зүй тогтлыг судлах, эрсдлийг тодорхойлох зэрэг ажлыг гүйцэтгэхэд түлхүү ашигласан.

Бүс нутгийн хамтын ажиллагаан дахь худалдааны олон улсын туршлагыг нарийн судалснаар Монгол Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах зэрэг боломжтой бүхий улс орныг оновчтой тодорхойлж, амжилттай хэлэлцээр хийж улмаар худалдаа, хамтын ажиллагааг сайн бэхжүүлсэн олон улсын туршлага, мөн түүнчлэн ДХБ-д элсэхдээ авсан үүрэг амлалт зэргийг хэрэгжүүлэхэд тус дөхөм болно. Бүс нутгийн хамтын ажиллагаан дахь худалдааны асуудлуудыг шийдвэрлэх замаар худалдааны эрх зүйн орчныг сайжруулах бодлого хэрэгжүүлж байна. Манай улсын хувьд чөлөөт зах зээл буюу өрсөлдөөнт зах зээл тул төр хувийн хэвшлийн хоорондын харилцааг зохицуулахад маш төвөгтэй бэрхшээлүүд бий. Эдийн засгийн энэхүү хүнд нөхцөлд дотоодын худалдаа арилжаа бүх зүйл төрөөс хамааралтай болж байгаа нь бизнес эрхлэгчдэд төр хувийн хэвшлийн хоорондын харилцаа дутмаг хэмээн дүгнэлж байгаа. Гэвч энэхүү эрх зүйн зохицуулалтыг хийхгүй тохиолдолд худалдаа арилжаа хэтэрхий чөлөөтэй явагдсан тохиолдолд түүнээс гарах үр дагавар эргээд эдийн засагтай маш хүнд нөхцөлд хүргэнэ.

Бүс нутгийн хамтын ажиллагаан дахь худалдааг улам эрчимжүүлэх зорилгоор хөрш болон бүс нутаг дахь улсуудтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, Торгоны зам төсөлд хамрагдаж амжилттай хэрэгжүүлэх улмаар АСЕАН - Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгт гишүүн орноор элсэн орох зэрэг олон боломж бий.

Бүс нутгийн хамтын ажиллагаан дахь худалдааны асуудлууд:

I. Бүс нутгийн хамтын ажиллагаа, эдийн засгийн интеграцчилалын нөхцөл, эрх зүйн орчин

Гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүсийн хэмжээнд тогтоосон худалдааны эрх зүйн хөнгөлөлттэй орчин, худалдааны саад тотгорыг арилгах арга хэмжээ нь ДХБ-ын хэмжээнд үүсэх олон талт хэлэлцээрийн үндэс болдог. ДХБ-ын олон талт хэлэлцээний хүрээнд боловсрогдож байгаа оюуны өмчийг хамгаалах, хүрээлэн буй орчин, стандарт, хөрөнгө оруулалт зэрэг асуудлууд бүс нутгийн хэлэлцээрүүдэд нэлээд өргөнөөр тусгагдаж байгаа нь эргээд олон талт хэлэлцээнд нааштайгаар нөлөөлнө. ДХБ-ын гишүүн орнуудын Сайд нарын 2001 онд Доха-д болсон бага хурлаас гаргасан Тунхаглалд, “бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүд нь худалдааг чөлөөлөх, түүнийг өргөжүүлэхэд болон хөгжлийг түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа”¹⁵⁴ хүлээн зөвшөөрсөн. Сайд нараас өгсөн олон талт хэлэлцээнд баримтлах удирдамжид, гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүсийг улам боловсронгуй болгож, эрх зүйг нийтийн жижигт ойртуулах, тэдгээрийн сөрөг нөлөө, эрсдэлийг багасгахад голлон анхаарахыг заажээ. Интеграци нь эхлээд **хөнгөлөлттэй худалдааны бүс** байгуулахаас эхэлдэг. Энд талууд харилцан буюу аль нэг талдаа худалдааны тодорхой хөнгөлөлт үзүүлж, тарифын бус саад тотгорыг бууруулдаг.

Чөлөөт худалдааны бүсийн орнууд нь өөр өөрийн оронд үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг хоорондоо татвараас чөлөөлж, гаалийн ажиллагааг хялбаршуулсан буюу байхгүй болгосон байдаг. Гэвч гишүүн орнуудын хувьд нийт бараа бүтээгдэхүүний хамрах хүрээг цаг хугацааны хувьд шаталсан маягаар хэрэгжүүлэх, эмзэг болох бараа, бүтээгдэхүүний хувьд тусгайлан тохиролцоод жагсаалтад оруулахгүй байх бололцоотой. **Гаалийн холбооны** гишүүн орнууд нь өөр хоорондын худалдаанд зах зээлээ нээхээс гадна гурав дахь орны орны хувьд гаалийн нэгдсэн бодлого баримталдгаараа интеграцчиллын илүү гүнзгий түвшин байна. **Нэгдсэн зах зээлийн** орнууд нь худалдаа, эдийн засгийн хөгжлийн бодлого нь төстэй болж уялдах ба удирдлага, менежментийг гишүүн орнуудаас байгуулсан олон улсын хэмжээний байгууллагаас хэрэгжүүлдэг болсон байна. **Эдийн засгийн холбооны** үед гишүүн орнууд нь худалдаанаас гадна эдийн засгийн нэгдсэн бодлого баримталж, нэгдсэн менежментэд ордгоороо онцлогтой.¹⁵⁵

Дэлхийн хоёр буюу түүнээс дээш орнуудын хооронд байгуулагдсан чөлөөт худалдааны бүс нь оролцогч орнуудын хооронд худалдааны хамгийн таатай нөхцөлийг бий болгохоос гадна бүс нутгийн интеграцчиллын үндэс болдгоороо ач холбогдолтой. Энд нэгдсэн зах зээл үүсч, хэмжээ нь тэлэгдэж, үйлдвэрлэл өсдөг. Мөн бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцчилал нь нийтлэг асуудлуудыг бүс нутгийн байгалийн баялаг, хөрөнгө санхүүгийн боломж, техник, технологи, оюуны чадамж, ажиллах хүчний нөөц дээрээ түшиглэн шийдвэрлэхэд

¹⁵⁴ WTO, November 2001, Declaration of the Fourth Ministerial Conference in Doha, Qatar

¹⁵⁵ Б.Санжмятав, УБ, 2015 он, Олон улсын худалдаа

тохиромжтой. Гаалийн холбоонд оролцогч орнууд нь гаалийн нэгдсэн нутаг дэвсгэрийг үүсгэдгээрээ онцлогтой.

Жижиг эдийн засгууд нь бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдсэнээрээ өөрийн эмзэг байдлыг зөөллөдөг. Үүний үр дүнд зах зээлийн хэмжээг тэлж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өөртөө үйлдвэрлэхэд ашиггүй буюу байхгүй бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр солилцоогоор авах бололцоотой болно. Бүс нутгийн хамтын ажиллагаа нь бас тээврийн зардал, хөрөнгө оруулалтын эрсдэлийг багасгаж, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлнө. Энэ байдал нь компаниудын зүгээс бүтээмжээ нэмэгдүүлэх, хөрөнгө оруулах сонирхлыг нь дэмждэг.¹⁵⁶ Гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүсийн өөр нэг онцлог гэвэл тодорхой бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадваргүй байвч тодорхой гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүсэд харьцангуй ашигтай болох боломж бүрддэг явдал юм.

Монгол Улс хэдийгээр Дэлхийн худалдааны байгууллагад 1997 онд гишүүнээр элссэн боловч тус байгууллагын 160 гаруй гишүүн оронтой аливаа бүс нутгийн болон хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээрт нэгдээгүй цорын ганц орон байсанд үүгээр цэг тавьж чадлаа. Манай улс Япон улстай анхны чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан явдал нь эдийн засгийн гадаад харилцааны салбарт сүүлийн 20 жилд гарсан том амжилт юм.

“Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр”-ийг “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, болон бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

ОХУ, БНХАУ болон гуравдагч хөрш улсууд, холбоодтой стратегийн болон иж бүрэн түншлэлийн харилцааг бататган бэхжүүлэх зорилгоор монголын “Талын зам”, хятадын “Торгоны замын эдийн засгийн бүс” санаачилга болон ОХУ-ын тэргүүлж байгаа “Евразийн эдийн засгийн холбоо”-ны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах 3 улсын “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөр боловсруулах тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан нь Монгол Улсын далайд гарцгүй байдлаас үүдэлтэй үр дагаврыг саармагжуулах, эдийн засгийн хөгжилд тулгарч буй гол бэрхшээл болох дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой боллоо.

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Тээврийн яамны төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн дэд сайд нарын Улаанбаатарын хоёрдугаар зөвлөгөөнөөр “Талын зам”, “Торгоны замын эдийн засгийн бүслүүр”, “Транс-Евразийн хөгжлийн бүслүүр” зэрэг гурван талын санаачилгын хүрээнд дамжин өнгөрөх ачаа тээврийг тодорхой хэмжээ, хугацаа заалгүйгээр нэмэгдүүлэх, хамтарсан тээвэр-логистикийн компани байгуулах, гурван улсыг дамнасан төмөр замын тээврийн коридорын хэсгүүдийг харилцан уялдаатай хөгжүүлэх, босоо тэнхлэгийн төмөр замын хоёр шинэ коридор байгуулах асуудлыг хамтран судлах, боловсрол, судалгаа шинжилгээний салбарт

¹⁵⁶ World Development report, 2005, p 65

хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг асуудлаар харилцан санал солилцож, зохих үр дүнд хүрлээ.¹⁵⁷

II. Бүс нутгийн гол түнш орнуудтай Япон, ОХУ, БНХАУ, БНСУ, АНУ, Канадтай хийж буй худалдаа

Монгол Улс 2015 онд экспорт 4817.5 сая ам.долларын барааг экспортолж, 6598.4 сая ам.долларын барааг импортолж, гадаад худалдааны эргэлт 11.4 тэрбум ам. долларт хүрчээ. Хэдийгээр Монгол Улс дэлхийн 160 орчим улстай худалдаа хийж байгаа боловч БНХАУ, ОХУ, Япон, Өмнөд Солонгос, АНУ, Канад зэрэг цөөхөн улс орон гадаад худалдаанд өндөр хувийг эзэлж байна.

Худалдааны гол түнш эдгээр улс орнууд Монгол Улсын гадаад худалдаанд 80 гаруй хувийг эзэлж байгаа ба манай гадаад худалдаа хоёр хөрш орноос, ялангуяа Хятад улсаас үлэмжхэн хамааралтай байна.

Харин эсрэгээр эдгээр орнуудын гадаад худалдаанд Монгол Улс өчүүхэн бага буюу экспортод 0.02-0.3, импортод 0.0005-0.2 хувийг эзэлж байгаа юм. Эндээс харахад бидний байгуулахыг зорьж буй ЧХХ нь түнш орнуудын хувьд “худалдааны бус агуулга”-тай (tradeless) болох нь харагдаж байна.

Хүснэгт № 2.1.

**МУ-ын гадаад худалдаанд түнш орнуудын,
түнш орнуудын гадаад худалдаанд МУ-ын эзлэх хувийн жин, 2015 он**

Монгол улсын гадаад худалдаанд түнш орнуудын эзлэх хувь	Түнш орнуудын гадаад худалдаанд Монгол улсын эзлэх хувь				
	Эргэлт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт
ОХУ	15.1	2.0	24.6	0.31	0.03
БНСУ	3.5	0.8	5.4	0.06	0.01
БНХАУ	56.6	92.2	30.7	0.14	0.21
Япон	4.4	0.2	7.4	0.04	0.002
АНУ	4.7	0.1	8.1	0.02	0.0005
Канад	1.9	1.9	1.9	0.02	0.05
Хувь	86.2	97.2	78.2		

Монголын экспортод олборлох үйлдвэрлэлийн түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн 95.0 орчим хувийг эзэлдэг бөгөөд нийт экспортоос үүнийг хасвал бусад салбаруудын жилийн экспорт 200-300 орчим сая ам.долларт эргэлддэг гэсэн тооцоог хийж болохоор байна. Тиймээс ЧХХ нь уул уурхайгаас бусад салбаруудын хувьд “худалдааны бус агуулгатай” болох нь илэрхий байна.

Экспортын бүтцэд томоохон хувийг эзэлж буй олборлох үйлдвэрлэлийн түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг тээвэрлэлтийн зардал бага шаарддаг, транзит тээвэрлэлт хийхгүйгээр худалдах боломжтой цорын ганц зах зээл болох Хятад улсад худалдаалдаг. Тээвэрлэлтийн өртөг зардал өндөр тул олборлох үйлдвэрлэлийн түүхий эдийг өөр улсад худалдах боломж хязгаарлагдмал.

¹⁵⁷ Гадаад харилцааны яам, 2015 он, Үйл ажиллагааны тайлан

Харин коксжих нүүрс, зэсийн болон молибдены баяжмал зэрэг олборлох үйлдвэрлэлийн түүхий эдийг боловсруулан кокс, зэс гэх мэт бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар тээвэрлэлтийн зардлыг бууруулах боломж бий. Олборлох үйлдвэрлэлийн салбарын түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадвал, тэдгээрийг металлургийн болон электрониксийн үйлдвэрлэл өндөр хөгжсөн Япон, Өмнөд Солонгос зэрэг орнуудад худалдаалах боломжтой. ЧХХ-ийг байгуулахдаа өөрийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортлох боломжийг нь нэмэгдүүлэхэд анхаарах явдал зүйн хэрэг. Гэвч нөхцөл байдалд хийсэн шинжилгээнээс үзэхэд түнш орнуудтайгаа өнөөдрийн экспортын бүтэцдээ тохируулж бус, харин ирээдүйд үйлдвэрлэх эцсийн бүтээгдэхүүндээ зориулан зах зээлийг бий болгох зорилгоор ЧХХ-ийг эхлүүлэх шаардлагатай байгаа юм.

Монгол Улсын импортын 80 гаруй хувийг аж үйлдвэрийн бараа, 20 орчим хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж байгаагаас үзэхэд гаднаас гол төлөв нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг худалдан авдаг гэсэн дүгнэлтийг хийж болохоор байгаа юм. Монгол Улсын экспорт, импортын бүтцийн аль алинаас нь үзэхэд нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг үйлдвэрлэлийг дотооддоо хөгжүүлэх шаардлага өндөр хэмжээнд байгаа нь мэдрэгддэг.¹⁵⁸

Даяаршин буй зах зээлд Монгол Улс амжилттай өрсөлдье гэвэл өөрийн үйлдвэрлэлийн харьцангуй давуу талд тулгуурласан үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай. Монгол Улсад олборлох үйлдвэрлэл болон мал ахуйд тулгуурласан харьцангуй давуу тал бүхий 2 том салбар байдаг. Тиймээс улс орны хөгжлийн урт хугацааны зорилтуудтай уялдаатайгаар мал аж ахуй, металлург болон газрын тос химийн үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх, эдгээр салбарт хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн стратегийг ЧХХ-ийг байгуулахдаа баримтлах нь зүйтэй юм.

III. Бус нутгийн гол түнш орнуудад Монгол Улсаас нийлүүлэх боломжтой бүтээгдэхүүн

Олон улсын худалдааны онолоор бол аливаа улс орон өөрийн харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр төрөлжиж, тэрхүү харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүнээ худалдаалах нь үр ашигтай гэж үздэг. Гэвч бид аль улс оронд ямар барааг худалдах боломжтой, аль улс орноос ямар барааг худалдан авах боломжтой вэ гэдгийг шууд тодорхойлоход бэрхшээлтэй. Учир нь харьцангуй давуу талыг тодорхойлохын тулд үйлдвэрлэлийн өртөг зардлын хэмжээг мэдэж байх ёстой, гэтэл улс орон бүрийн өвөрмөц онцлогоос бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд гарах зардал харилцан адилгүйн зэрэгцээ өнөөгийн түвшинд эдгээр зардлыг тооцож гаргаж чадахгүй байгаа юм. Иймээс өртөг зардлын ялгааг төлөөлж чадах өөр нэгэн үзүүлэлт болох харьцангуй давуу талыг тодорхойлох индексийг ашиглах болсон.¹⁵⁹

Унгар гаралтай эрдэмтэн Бела Баласса (Balassa, 1965) анх харьцангуй давуу талыг тодорхойлох индексийг ашиглах санааг дэвшүүлсэн. Түүнийхээр тодорхой

¹⁵⁸ ҮХШХ, 2013 он, "Худалдааны гол түнш орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж болон эрсдэл"

¹⁵⁹ Revealed comparative advantage or revealed export advantage

бүтээгдэхүүний хувьд энэ индексийг тооцохдоо тухайн улсын хувьд тухайн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жинг тухайн бүтээгдэхүүний дэлхийн нийт экспортод эзлэх хувийн жинд харьцуулах аргыг ашиглажээ. Ийм индексийн тусламжтайгаар бид түнш орнуудаасаа юу худалдан авч, ямар бүтээгдэхүүнийг худалдах боломжтойгоо тодорхойлж болох юм.

Аливаа бараа бүтээгдэхүүнийг худалдахын тулд зах зээлд тодорхой хэмжээний эрэлт байх ёстой бөгөөд тэрхүү эрэлтийг хангахуйц нийлүүлэлт ч мөн байх ёстой.

Бид түнш орнуудтай хийх худалдааны боломжийг тодорхойлохдоо импортын болон экспортын харьцангуй давуу талуудыг тооцох индексүүдийг ашигласан. Импортын харьцангуй давуу талын индексийг ашиглан түнш орнуудын худалдан авах боломжийг, экспортын харьцангуй давуу талын индексийг ашиглан манай орноос түнш орнуудад нийлүүлэх боломжтой бүтээгдэхүүнийг тодорхойлсон болно.

Импортын харьцангуй давуу талын индексийг тооцохдоо тухайн орны хувьд тухайн бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувийн жинг тухайн бүтээгдэхүүний дэлхийн нийт импортод эзлэх хувийн жинд харьцуулах байдлаар тооцоолсон.

Тодорхой бүтээгдэхүүний хувьд экспортын болон импортын харьцангуй давуу талын индексүүд нь адилхан их, өөрөөр хэлбэл, $RCA_{ij} > 1$, $RMA_{ij} > 1$ байх нөхцөлд тухайн бүтээгдэхүүнийг өөр хоорондоо худалдаалах боломжтой гэж үзсэн. Харин бусад тохиолдолд уг бүтээгдэхүүнийг худалдах боломжгүй.

Эдгээр индексүүдийн тусламжтайгаар худалдааны харьцангуй давуу талыг тодорхойлох индексийг тооцож болох ба энэхүү индексийг экспортын харьцангуй давуу талын индексийг импортын харьцангуй давуу талын индекс т харьцуулж тооцоолдог. Энэхүү индексээс нэгд, тухайн барааг худалдаалах боломжийг, хоёрт тухайн барааны салбар хоорондын худалдааны төлөв байдлыг харах боломжтой.

Бид худалдааны түнш орнуудад Монгол Улсаас нийлүүлэх боломжтой барааг тодорхойлохдоо дээр дурдсан индексүүдийг ашиглан нэг бүрчлэн шүүж үзлээ. Шинжилгээг сүүлийн 9 жилийн статистик мэдээлэлд тулгуурлан БТКУС-ын бүлгийн түвшинд хийсэн бөгөөд үр дүнг хавсралтаас харж болно.¹⁶⁰

Дээрх аргачлалыг ашиглан Монгол Улсаас экспортлох боломжтой, харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүнийг шүүж үзэхэд БТКУС-ийн 26, 05, 51, 71, 41, 74, 02, 25-р бүлгүүд харьцангуй давуу талтай, 57, 61-р бүлгийн барааны харьцангуй давуу тал алдагдах, 27-р бүлгийн барааны харьцангуй давуу тал сайжрах хандлагатай байсан. Үүнийг дараах хүснэгт №1.4-т харуулав.

Монгол Улсын экспортын харьцангуй давуу талд хийсэн шинжилгээнээс үзэхэд, харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүний дийлэнх хувийг Рикардогийн бүтээгдэхүүн буюу олборлох үйлдвэрлэл, мал аж ахуйн гаралтай түүхий эд зэрэг байгалийн баялагт түшиглэсэн бүтээгдэхүүн эзэлж байв.¹⁶¹

¹⁶⁰ Revealed import advantage

¹⁶¹ Revealed trade advantage

Хүснэгт № 3.1.

МУ-ын экспортын харьцангуй давуу талын индекс, БТКУС-ийн 2 орноор

Код	Нэр		2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
51	Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас; адууны хялгасан ээрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу.	RXA	47.40	43.11	63.71	90.36	94.62	46.68	55.96	40.96	29.57
		RMA	7.58	18.52	3.07	6.02	1.84	1.13	0.53	0.95	0.63
		RTA	6.25	2.33	20.74	15.01	51.55	41.20	105.07	43.18	46.81
		RC	1.80	0.80	3.00	2.70	3.90	3.70	4.70	3.80	3.80
26	Хүдэр, баяжмал, шаараг болон үнс.	RXA	72.50	70.99	53.49	64.07	65.49	62.33	52.05	32.22	27.22
		RMA	0.04	0.01	0.01	0.00	0.00	0.14	0.00	0.01	0.01
		RTA	1674.4	6869.3	9643.9	30289.1	23465.4	459.0	40775.1	6472.6	4193.5
		RC	7.40	8.80	9.20	10.30	10.10	6.10	10.60	8.80	8.30
25	Давс; хүхэр; шороон эрдэс, чулуу; шаварлаг эрдэс, шохой болон цемент	RXA	13.05	9.91	9.41	9.15	9.52	11.10	12.50	11.24	8.84
		RMA	2.76	2.81	2.93	3.45	3.67	2.88	3.21	3.06	3.04
		RTA	4.72	3.53	3.21	2.65	2.59	3.85	3.90	3.67	2.91
		RC	1.60	1.30	1.20	1.00	1.00	1.30	1.40	1.30	1.10
05	Мал амьтны гаралтай бүтээгдэхүүн.	RXA	21.04	18.80	17.12	10.42	8.70	7.99	9.23	5.65	5.98
		RMA	0.11	0.20	0.16	0.39	0.04	0.24	0.01	0.23	0.02
		RTA	188.16	95.16	107.97	26.73	222.67	33.69	797.28	25.08	400.25
		RC	5.20	4.60	4.70	3.30	5.40	3.50	6.70	3.20	6.00
41	Арьс, ширэн түүхий эд ба боловсруулсан арьс, шир.	RXA	27.21	9.03	10.62	11.76	9.72	1.80	3.01	2.74	2.81
		RMA	0.01	0.08	0.03	0.00	0.01	0.54	0.42	0.55	0.39
		RTA	3968.8	113.79	313.43	4401.36	888.91	3.31	7.26	4.96	7.21
		RC	8.30	4.70	5.70	8.40	6.80	1.20	2.00	1.60	2.00
71	Үнэт буюу хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлаар бүрсэн жирийн металл, тэдгээрээр хийсэн зүйлс;	RXA	11.71	13.89	16.46	8.80	5.97	4.24	3.23	2.62	1.83
		RMA	0.01	0.01	0.01	0.01	0.01	0.04	0.36	0.04	0.06
		RTA	1423.2	1902.4	1820.5	1247.70	417.30	112.80	9.06	66.56	28.51
		RC	7.30	7.60	7.50	7.10	6.00	4.70	2.20	4.20	3.40
02	Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн	RXA	3.42	1.53	1.32	1.91	1.56	1.61	2.63	1.64	0.93
		RMA	0.14	0.12	0.14	0.30	0.20	0.35	0.22	0.36	0.30
		RTA	23.71	12.21	9.11	6.33	7.72	4.52	12.18	4.62	3.10
		RC	3.20	2.50	2.20	1.80	2.00	1.50	2.50	1.50	1.10
74	Зэс ба түүгээр хийсэн эдлэл	RXA	0.72	1.18	1.07	0.98	1.06	1.46	1.20	1.09	0.46
		RMA	0.07	0.06	0.07	0.03	0.06	0.07	0.09	0.07	0.08
		RTA	9.93	19.24	15.97	29.39	17.45	21.67	13.46	16.12	5.78
		RC	2.30	3.00	2.80	3.40	2.90	3.10	2.60	2.80	1.80

27	Эрдэс түлш, газрын тос ба тэдгээрийн бүтээгдэхүүн; битумын эрдэс; эрдэс лав.	RXA	0.22	0.27	0.28	0.31	0.63	0.97	1.83	2.56	2.67
		RMA	1.87	1.86	1.90	1.96	1.86	1.39	1.18	1.19	0.93
		RTA	0.12	0.14	0.15	0.16	0.34	0.70	1.55	2.16	2.87
		RC	-2.10	-1.90	-1.90	-1.80	-1.10	-0.40	0.40	0.80	1.10
57	Хивс болон нэхмэл дэвсгэр	RXA	1.23	1.14	0.93	1.00	1.25	0.84	0.75	0.56	0.49
		RMA	0.86	0.42	0.43	0.41	0.44	2.53	2.68	2.32	1.75
		RTA	1.43	2.70	2.19	2.43	2.87	0.33	0.28	0.24	0.28
		RC	0.40	1.00	0.80	0.90	1.10	-1.10	-1.30	-1.40	-1.30
61	Сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэл	RXA	6.46	7.15	3.92	2.54	0.71	1.85	0.63	0.73	0.58
		RMA	0.92	0.94	0.69	0.58	0.16	0.75	7.02	3.92	5.61
		RTA	7.05	7.62	5.67	4.35	4.40	2.48	0.09	0.19	0.10
		RC	2.00	2.00	1.70	1.50	1.50	0.90	-2.40	-1.70	-2.30

ЧХХ-т тодорхой барааны талаар хэлэлцэхдээ хэдийгээр тухайн бараа нь Монгол Улсын хувьд экспортын харьцангуй давуу талтай байж болох ч түнш орны хувьд хэрэгцээт бараа мөн эсэх, түнш орны зах зээлд уг бүтээгдэхүүн өрсөлдөж чадах эсэх зэргийг судлан үзэж, тухайн нөхцөл байдалд тохирсон шийдвэрийг гаргах нь чухал. Ийм шинжилгээг хийхийн тулд түнш орны импортын харьцангуй давуу талыг тодорхойлох индексийг тооцох шаардлагатай бөгөөд энэхүү индексийн тусламжтайгаар тухайн оронд Монгол Улсаас экспортлох боломжтой, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүнийг олж тодорхойлж болно.

Түнш орнуудад бүтээгдэхүүн экспортлох боломжийг судлахдаа манай экспортын харьцангуй давуу тал дээр дурдсан импортын харьцангуй давуу талтай нь хэр зэрэг давхцаж буйг харах шаардлагатай тул бид түнш орон бүрийн хувьд дээрх давхцалыг тооцож үзлээ.

Хүснэгт № 3.2.

Монгол Улсын экспортын харьцангуй давуу тал ба гол түнш орнуудын импортын харьцангуй давуу талын давхцал

МУ-ын экспортын харьцангуй давуу тал өндөр бүлэг		Түнш орнуудын импорт			
		Харьцангуй давуу талтай		Харьцангуй давуу талгүй	
		RMA>2 Маш өндөр	2>RMA>1 Өндөр	1>RMA>0.5 Өндөр	RMA<0.5 Маш өндөр
02	Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн	ОХУ (4.9) Япон (2.3)		БНСУ (0.9), Канад(0.6), АНУ(0.4)	Хятад (0.2)
05	Мал амьтны гаралтай бүтээгдэхүүн	Япон(2.1)		АНУ(0.8), БНСУ(0.8) ОХУ(0.8), Хятад(0.6) Канад(0.5)	

25	Давс; хүхэр; шороон эрдэс, чулуу; шаварлаг эрдэс, шохой болон цемент		ОХУ(1.2) Хятад(1)	Япон(0.9), БНСУ(0.8) АНУ(0.6), Канад(0.6)	
26	Хүдэр, баяжмал, шаараг болон үнс.	Хятад(5) Япон(3.3) БНСУ(2.4)		ОХУ(0.9) Канад(0.7)	АНУ(0.2)
27	Эрдэс түлш, газрын тос ба тэдгээрийн бүтээгдэхүүн; битумын эрдэс; эрдэс лав.		БНСУ(1.9) Япон(1.9) АНУ(1.2)	Хятад(0.8), Канад(0.6)	ОХУ(0.1)
41	Арьс, ширэн түүхий эд (ангийн үснээс бусад) ба боловсруулсан арьс, шир.	Хятад(2.8)	БНСУ(1.3)		Япон(0.3), АНУ(0.2), Канад(0.2), ОХУ(0.1)
51	Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас; адууны хялгасан ээрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу.	Хятад(2.7)	БНСУ(1.1)	Япон(0.9)	Канад(0.3), АНУ(0.2) ОХУ(0.2)
57	Хивс болон нэхмэл дэвсгэр	Канад(2)	АНУ(1.2)	ОХУ(0.9), Япон(0.9)	БНСУ(0.2), Хятад(0.1)
61	Сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэл		АНУ(1.8) Япон(1.6)	Канад(0.8) ОХУ(0.2)	БНСУ(0.3) Хятад(0.1)
71	Үнэт буюу хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металлаар бүрсэн жирийн металл, тэдгээрээр хийсэн зүйлс;		АНУ(1.2)	Канад(0.9), Япон(0.8), БНСУ(0.6)	Хятад(0.3) ОХУ(0.1)
74	Зэс ба түүгээр хийсэн эдлэл	Хятад(2.8)	БНСУ(1.7)	АНУ(0.6), Канад(0.6)	Япон(0.4), ОХУ(0.2)

Дээрх хүснэгтээс харахад ОХУ-д 02, 25-р бүлгийн, Япон улсад 02, 05, 26, 27, 61-р бүлгийн, Хятад улсад 25, 26, 41, 51, 74-р бүлгийн, БНСУ-д 26, 27, 41, 51, 74-р бүлгийн, АНУ-д 27, 57, 61, 71-р бүлгийн, Канад улсад 57-р бүлгийн барааг тус тус экспортлох боломжтой юм. Түнш орнууд эдгээр барааны импортоор дэлхийн зах зээл дээр ямар байр суурьтай байгааг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт № 3.3.

**Гол түнш орнуудын дэлхийн тухайн бүлгийн барааны
импортод эзэлж буй байр, 2015 он**

Бүлэг	Нэр	Япон	ОХУ	БНСУ	Хятад	АНУ	Канад
02	Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн	1	5	10	12	7	13
05	Мал амьтны гаралтай бүтээгдэхүүн	3	20	11	6	1	19
25	Давс; хүхэр; шороон эрдэс, чулуу; шаварлаг эрдэс, шохой болон цемент	5	13	12	1	2	18
26	Хүдэр, баяжмал, шаараг болон үнс.	2	46	3	1	9	12
27	Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн; битумын эрдэс;	3	60	4	2	1	15
41	Арьс, ширэн түүхий эд (ангийн үснээс бусад) ба боловсруулсан арьс, шир.	22	48	6	1	12	35
51	Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас; адууны хялгасан ээрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу.	5	51	7	1	12	27
57	Хивс болон нэхмэл дэвсгэр	5	16	26	24	1	4
61	Сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэл	3	12	21	28	1	10
71	Үнэт буюу хагас үнэт чулуу, үнэт металл, үнэт металаар бүрсэн жирийн металл, тэдгээрээр хийсэн зүйлс;	11	35	22	10	1	9
74	Зэс ба түүгээр хийсэн эдлэл	12	36	5	1	3	40

Экспорт, импортын харьцангуй давуу талын давхцал, түнш орнуудын дэлхийн импортод эзэлж буй байр суурь зэргээс үзэхэд мал эмнэлэг, эрүүл ахуй, хорио цээрийн талын бэрхшээлүүдийг шийдвэрлэж чадвал мах болон хүнсний дайвар бүтээгдэхүүнийг Япон болон ОХУ-д экспортлох боломжтой болох нь харагдаж байна. Иймээс эдгээр орнуудтай ЧХХ байгуулах нөхцөлд SPS (sanitary and phyto sanitary) болон TBT (technical barriers to trade)-ийн асуудлаар хэлэлцэж, эдгээр асуудлаар хамтран ажиллах санал тавих нь зүйтэй юм.

Дээрх судалгаанаас үзэхэд мал амьтны гаралтай бүтээгдэхүүний гол зах зээл нь Япон, малын арьс, шир болон үс, ноос, түүнчлэн уул уурхайн хүдэр, баяжмал, зэсийн гол зах зээл нь Хятад улс, хивсний гол зах зээл нь Канад улс болох нь харагдаж байна.

Хэдийгээр манай улсын экспортын болон түнш орны импортын харьцангуй давуу талуудын давхцал нь Монгол Улсаас түнш орнуудад бараа түүхий эд экспортлох боломжийг харуулж байгаа ч чухам хэдий хэмжээний экспортыг хийх нь эдгээр барааны зах зээлд өрсөлдөх чадвараас шууд хамааралтай.¹⁶²

¹⁶² WTO, 1995. General agreement on tariffs and trade /GATT/

III. Чөлөөт худалдааны хэлэлцээрт хамруулах нийт барааны оновчтой хувийг тодорхойлох нь

ДХБ-ын аливаа гишүүн орнуудад ЧХХ байгуулах эрх нь нээлттэй бөгөөд хэлэлцэн тохирогч талууд нь эрх зүйн хувьд Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр /ТХЕХ/- ийн 24 дүгээр зүйл, Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр /ҮХЕХ/-ийн 5 дугаар зүйл, “Enabling clause” буюу хөгжиж буй орнуудад илүү тааламжтай нөхцөл олгох зохицуулалтад үндэслэн ийм төрлийн хэлэлцээрийг байгуулдаг. Хэлэлцээр нь сонирхогч орнуудын хоорондын худалдааны харилцааг улам хөнгөвчлөхийн зэрэгцээ гуравдагч оронтой хийх худалдаанд ямар нэг нэмэлт саад тотгорыг учруулах ёсгүй юм. Түүнчлэн хэлэлцээр ДХБ-ын хэлэлцээрийн хүрээнд, түүнд заасан шаардлагуудын хүрээнд нийцсэн байх шаардлагатай.¹⁶³

Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 24 дүгээр зүйлийн 5.b дэх хэсэгт заасны дагуу ДХБ-ын гишүүн улсууд ЧХХ болон гаалийн холбоо байгуулах эрхтэй. Энэ зүйлд зааснаар чөлөөт худалдааны хэлэлцээрт оролцогч талууд гаалийн татварыг бууруулах, үгүй болгох талаар хэлэлцээр байгуулдаг. Ийм төрлийн хэлэлцээрийг байгуулснаар чөлөөт худалдааны хэлэлцээртэй орнуудын хооронд гаалийн татвар болон тоо хэмжээний хязгаарлалт үгүй болох боловч бусад орнуудтай хийх худалдаанд тарифын болон тарифын бус хязгаарлалтууд хэвээр үлддэг.¹⁶⁴

ЧХХ байгуулагч орнуудын хооронд байгуулсан гэрээ хэлцлүүд нь ДХБ-ын хэлэлцээрт заасан тодорхой шаардлагуудыг хангаж байх ёстой. Тухайлбал, хэлэлцээрт оролцогч орнууд хоорондын худалдааны дийлэнх хэсгийн гаалийн татварыг тодорхой хугацаанд чөлөөлөх, хэлэлцээр байгуулсны дараа ЧХХ-ийн гишүүн бус гуравдагч орны худалдаанд үйлчилж байсан тарифын түвшин нь байгуулахаас өмнөх үеийнхээс өндөр биш байх, тарифын бус хязгаарлалтыг бий болгохгүй байх, ЧХХ-ийн үйлчлэлд хамаарах бараа бүтээгдэхүүн нь тухайн хэлэлцээрийн гишүүн улсын нутаг дэвсгэрээс гаралтай байх зэрэг нөхцлүүдийг хангасан байх шаардлагатай.

ЧХХ-т хамруулах нийт барааны хувь хэмжээг тодорхойлох нь хэлэлцээрийн чухал хэсэг мөн бөгөөд ТХЕХ 24-р зүйлийн 8(b) хэсэгт заасны дагуу хэлэлцээрт оролцогч орнууд гаалийн тарифыг нь тэглэх барааны нийт худалдаанд эзлэх хувь хэмжээг тохиролцдог. Хэлэлцээрт оролцож буй талуудын хувьд уг хэмжээг оновчтой тогтоох нь чухал байдаг боловч олон улсын туршлагаас үзэхэд, голчлон барааны үнийн дүнгийн 90-ээс дээш хувийн гаалийн тарифыг “тэглэх” хэлцэл хийжээ. Тухайлбал, Япон-Сингапурын ЧХХ-ээр Япон улс нийт импортын үнийн дүнгийн 94.7 хувь, Сингапур 100 хувийг гаалийн тарифаас чөлөөлсөн байна.

Ийнхүү барааны оновчтой хувь хэмжээг тогтоохын тулд хэлэлцээрт оролцогч талууд тарифаас чөлөөлснөөр улс оронд нь ноцтой хохирол учруулж болох зарим эмзэг барааны тарифыг хэвээр үлдээх буюу эсвэл түүнийг тарифаас үе шаттайгаар,

¹⁶³ WTO, 1995. General Agreement on Trade in Services/GATS/

¹⁶⁴ WTO, 1995. General agreement on tariffs and trade /GATT/

удаан хугацаанд чөлөөлөх талаар саналаа оруулж тохиролцдог.¹⁶⁵

Хүснэгт № 4.1.

Гаалийн тарифын талаар оруулах санал

№	Тариф буулгах	Тайлбар	Хамрах хүрээ
1	“А” - шууд “0”	Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон үеэс татварыг тэглэх	Эдгээр нь гол төлөв мэдрэмжгүй бараа байна. (Ийм барааг тарифаар хамгаалаад үр дүн гарахгүй)
2	“ВЗ” – үе шаттай бууруулах	Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон үеэс тодорхой үе шатаар бууруулах	Гол төлөв шинээр хөгжиж буй салбаруудыг ийм байдлаар хамгаалах бөгөөд тарифийн хамгаалалтыг тухайн хамгаалж буй салбарын хөгжилтгүй уялдуулан алгуур үе шаттайгаар цуцалдаг
3	“ТQ” – тарифийн квот	Тодорхой тооны бараанд хөнгөлөлт олгоод түүнээс илүү гарсанд нь ердийн тарифыг ноогдуулах	Үндэсний үйлдвэрлэлд бүтээгдэхүүнээ борлуулах боломж олгохын тулд зах зээлийн эрэлт болон үндэсний үйлдвэрлэлийн нийлүүлэлтийн боломжийн зөрүүтэй тэнцэх хэмжээний квот тотоож, квотоос давсан хэсэгт ердийн тарифийг мөрддөг.
4	“R” – цаашид хэлэлцэх	Тодорхой хугацаагаар хойшлуулах	Ийм бараа нь мэдрэмж өндөртэй, дотоодын чухал ач холбогдол бүхий салбарын бараа байх бөгөөд цаашид тарифаар хамгаалах нь ач холбогдолтой эсэхийг харах зорилгоор ийнхүү хойшлуулдаг.
5	“X” – хэлэлцэхгүй	Хэлэлцээрээс гадуур үлдээх	Ийм бараа нь нэгд, мэдрэмж өндөртэй, хоёрт улсын эдийн засагт онцгой ач холбогдол бүхий бараа байна.
6	“SS” – одоогийн тарифийн түвшинг өсгөхгүй	Нэрлэсэн тарифаас өсгөхгүй байх	Мэдрэмжтэй бараа

Онолын хувьд тарифаас чөлөөлөх буюу тарифыг бууруулахдаа нэгд, тухайн бүтээгдэхүүн нь экспорт, импортын харьцангуй давуу талын давхцал, хоёрт тухайн барааны үнийн мэдрэмж зэргийг харгалзан үзэх шаардлагатай. Экспорт, импортын харьцангуй давуу талын давхцлыг тооцох нь тухайн барааны импорт зайлшгүй чухал эсэх, тухайн барааг ЧХХ-т оролцогч орноос худалдан авах нь хамгийн үр ашигтай эсэхийг шалгаж буй хэрэг юм. Харин мэдрэмжийг тооцоолох хэд хэдэн үндсэн шалтгаан бий. Нэгд, дотоодод үйлдвэрлэдэг бараа гол төлөв импортын үнийн мэдрэмжтэй байдаг тул ийм барааны тарифыг өөрчлөх буюу тарифаас татгалзсанаар үнэ буурч, үнийн бууралт нь дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулж болзошгүй байдаг. Хоёрт, зарим тохиолдолд мэдрэмжтэй барааны тарифийг бууруулснаар үр ашиг багатай хэрэглээ их хэмжээгээр нэмэгдэж болзошгүй юм. Гуравт, бараа мэдрэмжтэй байгаа нөхцөлд л үндэсний үйлдвэрлэлийг тарифаар хамгаалах боломжтой байдаг.¹⁶⁶

¹⁶⁵ GATT Art.XXIV 8(b): “substantially all the trade”

¹⁶⁶ WTO, 1995. General agreement on tariffs and trade /GATT/ Ихэнх тохиолдолд 10 жилийн хугацаатай байдаг

Улс орнуудын туршлагаас харахад хэлэлцээр хүчин төгөлдөр болсон үеэс дор хаяж нийт үнийн дүнгийн 50 хувийн тарифыг тэглэсэн байна. Туршлагаас үзэхэд, гол төлөв дотоодод үйлдвэрлэх буюу эсвэл дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ хангах боломжгүй, тухайн улсын үндэсний аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлтэд сөрөг нөлөөгүй барааны хувьд тарифыг нь тэглэдэг байна.

ЧХХ-ээр хамруулах нийт барааны оновчтой хувийг тодорхойлохдоо экспорт, импорт харьцангуй давуу тал, тэдгээрийн давхцал, үнийн мэдрэмжийг харгалзан үзэхээс гадна нийт импортод эзлэх хувь, төсвийн орлогод үзүүлэх нөлөөллийг ч харгалзан үзэх шаардлагатай. Үүний тулд түнш орноос импортолж буй барааны бүтцэд шинжилгээ хийж, өндөр хувь хэмжээг эзэлж буй барааг тарифаас чөлөөлөх буюу тарифыг нь бууруулснаар гарч болох үр дагаварыг судлах шаардлагатай юм. Ялангуяа нийт импортод 10-аас дээш хувийг эзэлж буй барааг тарифаас зайлшгүй чөлөөлөх шаардлагатай тул ийм барааг тарифаас шууд чөлөөлөх үү, эсвэл үе шаттайгаар чөлөөлөх үү гэдгийг улс орны эрх ашигт ашигт нийцүүлэн шийдвэрлэх шаардлагатай.

Хүснэгт № 4.2.

Монгол Улсын худалдааны гол түнш орнуудаас импортлож буй гол нэрийн бараа, тэдгээрийн хувийн жин, 2016 оны 10 сарын байдлаар¹⁶⁷

Түнш орон	Монгол улсын нийт импортод эзлэх хувь	Гол нэрийн импортын бараа, нийт импортод эзлэх хувийн жин	Нийт
Япон	7.4%	Тээврийн хэрэгсэл (70.5%), Машин ба механик тоног төхөөрөмж (14.8%)	85.3%
ОХУ	24.6%	Газрын тосны бүтээгдэхүүн (68.0%), хар төмөрлөг (4%), тээврийн хэрэгсэл (4%)	76.0%
БНСУ	5.4%	Тээврийн хэрэгсэл (40%), машин ба механик тоног төхөөрөмж (20%), нефтийн бүтээгдэхүүн (6.4%), цахилгаан машин, төхөөрөмж, хэрэгсэл (4%)	70.4%
Хятад	30.7%	Тээврийн хэрэгсэл (21.5%), машин ба механик тоног төхөөрөмж (18.1%), төмөр гангаар хийсэн эдлэл (12.8%), Цахилгаан машин, төхөөрөмж, хэрэгсэл (12.1%), хар төмөрлөг (4.6%)	69.1%
АНУ	8.1%	Машин ба механик тоног төхөөрөмж (39.3%), тээврийн хэрэгсэл (30.3%), хаймран эдлэл (5%),	74.6%
Канад	1.9%	Машин ба механик тоног төхөөрөмж (46.4%), цахилгаан машин, төхөөрөмж, хэрэгсэл (24.5%), төмөр болон гангаар хийсэн эдлэл (15.3%)	86.2%

¹⁶⁷ Монголын Гааль, 2016.10, Гаалийн статистикийн мэдээ

Гаалийн статистик мэдээллээс үзэхэд Японоос импортоор авч буй барааны дийлэнх хэсгийг дотоодод үйлдвэрлэдэггүй, мэдрэмжгүй бараа эзэлж байв. Япон улстай ЭЗТХ байгуулснаар, ТХЕХ-ийн 24-р зүйлд заасан нөхцөлийг баримтлан авч үзвэл, ойрын жилүүдэд тус улсаас импортолж буй барааны бүтцэд томоохон өөрчлөлт гарахгүй бол хэлэлцээрийн хүрээнд суудлын автомашины гаалийн татварыг зайлшгүй “тэглэх” шаардлагатай болох нь.

Гэхдээ үүнд бодлоготойгоор хандах нь чухал. Автомашин нь байгаль орчинд хор хөнөөлтэй бараанд тооцогддог тул эхний ээлжинд хий, нарны энергиэр явдаг машинууд, түүнчлэн гибрид хөдөлгүүртэй болон моторын багтаамж багатай автомашиныг тарифыг нь шууд тэглэх “А” хэлбэрт оруулж болох юм. Үүнээс бусад автомашины тарифыг үе шаттайгаар бууруулахаар тохиролцож болно.

Түүнчлэн бусад гол түнш орнуудтай ЧХХ байгуулсан тохиолдолд: ТХЕХ-ийн 24-р зүйлд¹⁶⁸ заасны дагуу БНСУ-аас импортолж буй тээврийн хэрэгсэл, цахилгаан болон механик машин ба тоног төхөөрөмж, Хятад улсаас импортолж буй тээврийн хэрэгсэл, цахилгаан болон механик машин ба тоног төхөөрөмж, төмөр болон гангаар хийсэн эдлэл, АНУ-аас импортолж буй машин ба механик машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, Канад улсаас импортолж буй машин болон механик машин, тоног төхөөрөмж, цахилгаан машин, төхөөрөмж, хэрэгсэл, төмөр болон гангаар хийсэн эдлэл зэрэг барааг импортын гаалийн татварыг чөлөөлөх шаардлага гарахаар байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улс бол далайд шууд гарах гарцгүй, олон улсын хэмжээнд гадаад тээвэрлэлтийн зардлын түвшингээр хамгийн өндөртөйд тооцогддог орнуудын нэг бөгөөд тээвэрлэлтийн өндөр өртөг зардал нь Монголын гаралтай барааны өрсөлдөх чадварыг бууруулж, импортолж буй барааны үнийг өндөрсгөж байдаг.

Онолын хувьд дээрх тээврийн өртөг зардлыг бууруулах хоёр үндсэн арга бий. Нэгдүгээрт, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, хоёрдугаарт, газарзүйн байршлын хувьд ойрхон улс орнуудтай худалдаа хийх буюу ЧХХ байгуулах явдал юм. Сүүлийн жилүүдийн статистик мэдээллээс үзэхэд, Монгол Улсын нийт экспортын 95 орчим хувийг уул уурхайн болон мал аж ахуйн гаралтай түүхий эзэлж байгаа ба үлдэх 5 хүрэхгүй хувийг аж үйлдвэрийн хагас боловсруулсан болон эцсийн боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнүүд эзэлдэг.¹⁶⁹ Монголын боловсруулсан ба хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспорт нь жилийн 200-300 орчим сая долларт эргэлддэг бөгөөд үүнийг ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, АНУ, Канад зэрэг орны импорттой харьцуулахад өчүүхэн бага тоо болох нь тодорхой юм.

Худалдааны гол түнш орнуудтай ЧХХ байгуулах нь Монголын гаралтай барааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гол арга замуудын нэг мөн боловч эдийн засгийн өнөөгийн бүтэц тогтолцооны нөхцөлд ЧХХ байгуулах замаар үйлдвэрлэл,

¹⁶⁸ WTO, 1995. General agreement on tariffs and trade /GATT/

¹⁶⁹ Монголын Гааль, 2016.10, Гаалийн статистикийн мэдээ

экспортоо дэмжих боломж хязгаарлагдмал байна. ЕТЗ-т тулгуурлан хийсэн шинжилгээ дээр дурдсан 6 улсын алинтай нь ч ЧХХ байгуулахад үйлдвэрлэл, ДНБ, экспорт, импорт маш бага хэмжээгээр нэмэгдэнэ гэдгийг харуулж байна.

Харин өрсөлдөх чадвар өндөртэй уул уурхайн салбарын түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүнд зах зээлийг бий болгох нь ЧХХ байгуулах хүрээнд тавигдаж эн тэргүүний зорилт юм. Мэдээж хэрэг энэ нь уул уурхайн салбарын бүтээгдэхүүнд эцсийн боловсруулалт хийх үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлсэн нөхцөлд Монгол Улсад ач холбогдолтой байх болно.

Монголын экспортын өнөөгийн бүтцэд уул уурхайн түүхий эд зонхилж байгаа бөгөөд эдгээр түүхий эдийг улс дамнуулан худалдаалах нь тээвэрлэлтийн өндөр өртөг зардал шаарддаг. Тиймээс уул уурхайн салбарын үйлдвэрлэгчид олборлосон түүхий эдээ транзит тээвэрлэлтийн зардал шаардахгүйгээр худалдах боломжтой цорын ганц зах зээл болох БНХАУ-д нийлүүлдэг байна.

Бидний хийсэн судалгаагаар БНХАУ-тай ЧХХ байгуулах нь урт хугацаандаа үр ашиггүй байна. БНХАУ ган, зэс зэрэг металлын үйлдвэрлэл, хэрэглээ, экспортоор Дэлхийн тэргүүлэгч орнуудын эгнээнд багтдаг тул уул уурхайн түүхий эдийн эрэлт өндөртэй оронд тооцогддог. Тиймээс БНХАУ-тай ЧХХ байгуулсан нөхцөлд манай дотоодын зах зээл дээр урт хугацаанд нь металл боловсруулах үйлдвэрлэлд шаардлагатай стратегийн түүхий эдийг худалдан авах өрсөлдөөнийг бий болгож болзошгүй байна. Дотоодын зах зээл дээрх түүхий эдийн төлөөх иймэрхүү өрсөлдөөний улмаас Монголын арьс шир боловсруулах, ээрмэл, сүлжмэлийн үйлдвэрүүд хаалгаа барьсан жишээ харуулна. Хэдийгээр БНХАУ-ын импортын харьцангуй давуу тал нь манай экспортын харьцангуй давуу талтай давхцдаг боловч ЧХХ байгуулах нь Монгол Улс уул уурхайд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлоготой зөрчилдөх болно.¹⁷⁰

ОХУ нь дэлхийн зах зээлд Монголтой ижил төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалдаг, экспортын бүтцийн хувьд нэлээд төсөөтэй орон тул ЧХХ байгуулах нь төдийлөн ач холбогдол багатай байх болно.

Нөгөөтэйгүүр ОХУ, БНХАУ зэрэг том орнуудтай ЧХХ байгуулах нь тэдгээр орнуудаас хараат байдлыг нэмэгдүүлж, үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй. Энэ 2 оронтой ЧХХ байгуулаагүй өнөөгийн нөхцөл байдал нь тэдгээр орнуудаас хамаарах хамаарлыг сулруулж байгаа нь бодит үнэн юм.

ОХУ нь манай орны гадаад худалдаанд чухал байр суурийг эзэлдэг, дэлхийн томоохон эдийн засаг бүхий орон мөн боловч энэ орны экспортын ерөнхий бүтэц нь Монголтой төстэй, уул уурхайд тулгуурласан байдаг. Тиймээс Монгол Улс уул уурхайн салбарын бүтээгдэхүүнээ ОХУ-д экспортлох боломжгүй юм. Түүнчлэн манай орноос ОХУ-д экспортлож буй уул уурхайн бус бүтээгдэхүүн үнийн мэдрэмжгүй байгаагаас үзэхэд, ЧХХ байгуулснаар Монголоос ОХУ-д экспортлох уул уурхайн бус бүтээгдэхүүний хэмжээ төдийлөн нэмэгдэхгүй бөгөөд харин эсрэгээр ОХУ-ын зүгээс манай зах зээлд худалдаалах барааны хэмжээ эрс өсөх

¹⁷⁰ Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, 2013, Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс Хоорондын Чөлөөт Худалдааны Хэлэлцээрийн Төслийн Үндэслэл

магадлалтай юм. Тиймээс ЧХХ байгуулснаар ОХУ-тай хийж буй худалдааны алдагдлыг улам бүр нэмэгдүүлж болзошгүй.

Одоогоор ОХУ-аас импортолж буй барааны 90 гаруй хувь нь гаалийн татваргүй байгаа тул ОХУ-тай ЧХХ байгуулах нөхцөлд дэлгэх “хөзөр” байхгүй юм. Түүнчлэн ОХУ-аас импортолж барааны 70 орчим хувийг эзэлдэг газрын тосны бүтээгдэхүүнийг Монгол Улс дотооддоо үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байгаа тул ЧХХ байгуулах нь манай улсад газрын тос химийн үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй зөрчилдөх болно. Тиймээс ОХУ-тай ЧХХ байгуулах нь өнөөгийн эдийн засгийн хувьд үр ашигтай шийдэл биш юм.¹⁷¹

Ерөнхийдөө хоёр хөрш ОХУ, БНХАУ-ын аль алинтай нь ЧХХ байгуулах нь төдийлөн ач холбогдолтой бус байна. Үүнийг ЕТЗ-ын тооцооллын үр дүн давхар нотолж байна. Монгол Улс ирээдүйн хөгжлийнхөө зорилтуудтай уялдуулж үзвэл, ЧХХ-ийг байгуулах ажлыг хөрш орнуудаасаа бус, тэдгээрийн гадна хүрээнээс эхлэх нь зүйтэй юм.

Харин Монгол Улс өрсөлдөх чадвар өндөртэй уул уурхайдаа тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг зорьж буй өнөөгийн нөхцөлд шинээр үйлдвэрлэх бүтээгдэхүүндээ зориулж зах зээлийг бий болгох зорилгоор электроникс, машины үйлдвэрлэл, хүнд аж үйлдвэр өндөр хөгжсөн Япон, БНСУ, АНУ-тай ЧХХ байгуулах талаар ажиллах шаардлагатай. Зарчмын хувьд энэ нь Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогын ерөнхий чиг шугамд нийцэж байгаа бөгөөд эдгээр орнуудтай ЧХХ байгуулахдаа өөрийн орны өнөөгийн экспортын бүтцэд нийцүүлж бус, харин ирээдүйн бүтцээ харж яриа хэлцэл хийх шаардлагатай. Учир нь томоохон орд газруудыг эргэлтэд оруулснаар Монгол Улсын гадаад худалдааны эргэлт өнөөгийн түвшнээсээ 5-6 дахин өсөх магадлалтай байна.

Өнөөдөр Монгол Улсын нийт экспортын хэмжээ 4.6 тэрбум долларт хүрсэн нь том тоо мөн боловч түүний 95 орчим %-ийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Уул уурхайн бус салбарын бүтээгдэхүүний экспорт жилийн 200-300 сая долларт эргэлдэж байгаа бөгөөд БНХАУ-аас бусад орнуудтай хийж буй уул уурхайн бус бүтээгдэхүүний жилийн экспорт 30 сая ам.доллараас хэтрэхгүй байгаа юм.

ЧХХ байгуулснаар худалдааны эргэлт 1%-иас хэтрэхгүй хэмжээнд өсөх тооцоо гарч байгаа бөгөөд уул уурхайн бус салбарт ч ийм хэмжээгээр өсөх тооцоо гарсан. Хэрвээ гэрээ хэлцлээс алт, зэс, нүүрс, молибден, цайр, хар төмөрлөг, газрын тос зэргийг хасч тооцвол, жилд экспортоо 200-300 мянган доллараар нэмэгдүүлэхийн тулд жил дамнасан олон зүйл, заалт бүхий ЧХХ байгуулах шаардлагатай юу гэсэн асуулт гарах нь зайлшгүй юм.

Тиймээс ЧХХ-ийг үйлдвэрлэлийн өнөөгийн бүтцийг харж бус, ирээдүйн бүтцийг тооцоолсны үндсэн дээр байгуулах нь чухал байгаа билээ. Ийм хэлэлцээрийг байгуулах нь өнөөдөр “худалдааны бус агуулгатай” байж болох боловч ирээдүйд өндөр ач холбогдолтой байх болно. Үүнийг тооцоолол давхар нотолсон.

¹⁷¹ Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, 2013, “Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын Чөлөөт Худалдааны Хэлэлцээр”-ийн төслийн үндэслэл боловсруулах судалгааны ажлын тайлан

НОМ ЗҮЙ

1. Д.Авирмэд, Олон улсын худалдаа ба эдийн засаг, УБ, 2012
2. Э.Гүргэмжав, А.Амартүвшин, Олон улсын худалдаа, УБ, 2009 он
3. ДХБ: Олон улсын худалдаа, эдийн засгийн харилцааны эрх зүйн үндэс болох нь, ГЕГ-ын дэргэдэх Гааль, эдийн засгийн сургууль, УБ, 2010
4. Олон худалдааны хэлэлцээний Уругвай үе шатны дүнд байгуулсан эрх зүйн баримт бичгүүд, Улаанбаатар, 2000
5. Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, Б.Санжмятав, УБ, 2006
6. Б.Санжмятав, Олон улсын худалдаа, УБ, 2013, 2015
7. Б.Санжмятав, Дэлхийн эдийн засаг, УБ, 2014, 2015
8. ДХБ дахь Монгол Улс, Улаанбаатар, 2003
9. Ц.Далай Д.Ундрах “Олон Улсын эдийн засаг онол ба бодлого” УБ 2006 он
10. МУГХЯ БТ-хэлтэс “ЗГ-ын тогтоол” эмхтгэл Золзаяа, УБ, 2014
11. Development, Trade and WTO – Handbook
12. АНУ-ын Азийн сангаас хэрэгжиж байгаа Монгол улсад засаглал ил тод байдлыг дэмжих төсөл., 2014
13. Олон улсын хувийн эрх зүй: Баримт бичгийн эмхэтгэл, Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн хууль зүйн сургууль, Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төв, Улаанбаатар, 2011
14. Москвагийн Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн багш нарын бичсэн “Олон улсын эдийн засгийн харилцаа” сурах бичиг, Д.Авирмэд Монгол хэлнээ хөрвүүлсэн, УБ, 2005 он
15. Бизнес эрхлэгчдэд зориулсан гарын авлага: Гадаад худалдааны бичиг баримт, МҮХАҮТ, УБ, 2007
16. Гадаад хэргийн яамны 2015 оны үйл ажиллагааны тайлан
17. International Trade Statistics, 2014, www.wto.org
18. World Trade Report, 2013: Factors shaping the future of the world trade
19. TPRB: government Report of Mongolia, 2014, www.wto.org
20. TPRB: Secretariat Report on trade policy of Mongolia, 2014, www.wto.org
21. TPRB: Minutes of meeting, 24 and 26 September 2014

Цахим хуудас:

1. www.legal.info
2. www.nso.mn
3. www.mongolbank.mn
4. www.worldbank.org
5. www.adb.org
6. www.imf.org
7. www.wto.org
8. www.unctad.org
9. www.open-government.mn
10. www.codos.gov.do
11. www.trademap.org